



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, 42,173,913.04 (дөчин хоёр сая нэг зуун далан гурван мянган есөн зуун арван гурван төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баттөр, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд (Говь-Алтай аймгийн ардын дуу бүжгийн "Алтай" чуулга) эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 310 дугаар тогтоолын хавсралтын 10 дугаар мөрийг хүчингүйд тооцсугай;

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

13201044

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн  
2 дугаар тогтоолын хавсралт

**"МИАТ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, ДАНСНААС ХАСЧ, ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| Д/д      | Автомашины марк, улсын дугаар                                              | Үйлдвэрлэсэн/<br>ашиглалтанд<br>орсон он | Нийт гүйлт<br>/км/ | Балансын үнэ,<br>хуримтлагдсан элэгдэл<br>(төгрөг)                                               |
|----------|----------------------------------------------------------------------------|------------------------------------------|--------------------|--------------------------------------------------------------------------------------------------|
| 1        | X County маркийн 15-95 УБС<br>улсын дугаар, арлын дугаар<br>HD17LP3C017538 | 2005/2006                                | 740900             | 42,173,913.04                                                                                    |
| Нийт дүн |                                                                            |                                          |                    | 42,173,913.04                                                                                    |
|          |                                                                            |                                          |                    | (дөчин хоёр сая нэг зуун<br>далан гурван мянга есөн<br>зуун арван гурван төгрөг<br>дөрвөн мөнгө) |